

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Европ эмэгтэйчүүдийн төлөөх залбирал1

Харчирхалтай нь Европт хүний наймаа газар авсан хэвэ эр байгаа бөгөөд хохирогчдын ихэнх нь бэлгийн мөлжлөгт өртдөг. Европын Найдвар доторх Эмэгтэйчүүд үйлчлэл нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүдэд сайн мэдээг түгээж, тэднийг биеэ үнэлэхээс зайлсхийхэд нь зориулж "Нуугдсан эрдэнэ" хөтөлбөрөөр дамжуулан тэдэнд тусалж, тэднийг эдгээх шинэ цуврал нэвтрүүлгийг бүтээж байна. Тэд уг хөтөлбөрийг сонсож, Христ дотор шинэ дүр төрхтэй болох болтугай. .



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Бурхан минь, Албани дахь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хүчирхийлэгчдийг илчлэх зоригтой болтугай. Эдгээр эмэгтэйчүүд Есүсээс иэрх эдгэрэл хийгээд итгэл найдварыг авах болтугай. (Дуу. 130:7)
2. Э з э н минь ээ, Бельгийн TWR "Найдвар доорх эмэгтэйчүүд хөтөлбөрийн мандах ба гялалзах" нэвтрүүлгийг бэлтгэж байгаа Анжад урам зориг өгөөч. (Мат. 10:20)
3. Бурхан аав аа, Хорват хэл дээрх "Найдвар доторх эмэгтэйчүүд" хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн зүрх сэтгэлд гүн гүнзгий нөлөөлсөн, амьдралыг нь өөрчилсн нэвтрүүлэг байгаасай хэмээн бид залбирч байна. (Дуу. 119:105)
4. Аав аа, Дани улсад боолын нөхцөлд амьдарч, бэлгийн мөлжлөгт болон хүчирхийлэлд өртөн айж амьдарч буй эмэгтэйчүүдийг тайтгарал, хамгаалалт, аврал нь Та байгаач хэмээн залбирч байна. (Эх. 16:13)

5. Эзэн минь, Европ дахь дүрвэж очсон эмэгтэйчүүд эрчүүдтэй харилцах харилцаандаа мэргэн ухаантай байж, нээлттэй харилцахал нь Та туслаач. (Дуу. 32:8)
6. Хайртай дотны хүмүүс нь амиа хорлосон Гренландын хүмүүсийн гэр бүлүүд Тан дээр ирж эдгэрэлийг авах болтугай хэмээн залбирч байна. Тэд үхлийг сонгохын оронд тайтгарал амар амгаланг олж аваасай гэж бид залбирч байна. (Мат. 11:28)
7. Эзэн минь, нийгмийн сүлжээн дэх өөрийгөө бусадтай харьцуулж байхдаа зовлон зүдгүүр, дарамтыг мэдэрдэг Финлянд эмэгтэйчүүдийг Есүс Христ доторх өөрийн жинхэнэ үнэ цэнийг олж хараасай хэмээн бид залбирч байна. (Сур. 3:15)
8. Эзэн минь, Болгар, Румын улсын хүн худалдаалах гэмт хэргийн золиос болох эрсдэлтэй охид, эмэгтэйчүүд гэр бүлүүдтэй сажилладаг байгууллагуудад шаардлагатай нөөц боломжоор Та хангаач. (2 Кор. 9:8)
9. Аваа, бид таныг Францын эмэгтэйчүүд бэлгийн дарамтанд өртөхөөс хамгаалаач хэмээн Танаас гуйж байна. (Дуу. 116:6)
10. Бурхан минь, Герман дахь шинэ ERF болон Найдвар доторх Эмэгтэйчүүдийн үндэсний зохицуулагч Стефани Нибэд үйлчлэлээ илүү олон зуучлагч, хандивлагчдад таниулах бүтээлч санаануудыг өгөөч хэмээн залбирч байна. (Дуу. 34:1)
11. Эзэн минь, Нидерландад эмэгтэйчүүдэд сайн мэдээ дамжуулдаг байгууллагуудад хэрхэн үйлчлэхэд нь Та туслаач. эмэгтэйчүүд биеэ үнэлэхээс чөлөөлөгдөж, Таны авралын сайн мэдээг хүлээж авах болтугай. (Гал. 5:1)
12. Аав аа, Македонид эмэгтэйчүүдийг амьтдаас дорд үздэг үзэл арилж, эмэгтэйчүүдийн алдагдсан Христ дотор сэргээгдэх болтугай хэмээн залбирч байна. (Ром. 8:14-17)
13. Эзэн минь, Норвеги дахь Христэд итгэгч ээжүүд өдөр бүр өөрийн амьдрал, бурханлаг үлгэр жишээгээр дамжуулан хүүхдүүддээ Есүсийн хуваалцах хүч чадал, урам зоригийг өгөөч. (Тит 2:7)
14. Бурхан минь, Польшийн олон өвчтөн энэ үнэтэй эмчилгээ хийлгэхээр гадаад руу явж чадахгүй байгаа иргэдийн төлөө залбирч байна. Польшид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон тэр дундаа тархины хорт хавдрын хагалгаа хийх чадварыг сайжруулахын төлөө залбирч байна. (Дуу. 40:7)

